



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"Өндөрхаан" ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

УЛААНБААТАР ХОТ, 2025 ОН

"ИНТЕР АУДИТ" ХХК



АГУУЛГА

I. ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

II. ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

III. 2024 ОНЫ АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

IV. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2025.03.11

"ӨНДӨРХААН" ХК-ИЙН МЭДЭЭЛЭЛ

КОМПАНИЙН НЭР:	"Өндөрхаан" ХК
РЕГИСТРИЙН ДУГААР:	2035987
КОМПАНИЙН УДИРДЛАГА:	Ц.Тайшир
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ:	Менежментийн зөвлөгөө өгөх
КОМПАНИЙН ХАЯГ:	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сентрал Тауэр, 17 давхар
УТАС:	93335099

АУДИТЫН КОМПАНИЙН МЭДЭЭЛЭЛ



АУДИТОР, МЭРГЭШСЭН НЯГТЛАН БОДОГЧИД
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: Ч.МӨНХБАЯР

Аудитын компанийн хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р
хороолол, Самбуугийн гудамж, 2м,
Эн тауэр, 802 тоот

Холбогдох:

Утас 99004529
Вэбхуудал www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: [interaudit.mn](https://www.facebook.com/interaudit.mn)
Мэйл хаяг: info@interaudit.mn

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2025.03.11

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

1

"Өндөрхаан" ХК-ийн 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

"ӨНДӨРХААН" ХК-ИЙН УДИРДЛАГАД

ДҮГНЭЛТ

Бид 2024 оны 12 дугаар сарын 31-нээр тасалбар болгосон санхүүгийн байдлын тайлан, уг өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн "Өндөрхаан" ХК (цаашид "Компани" гэх)-ийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний үзэж буйгаар "Өндөрхаан" ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал ба уг өдрөөр дуусгавар болсон орлогын дэлгэрэнгүй тайлан ба мөнгөн гүйлгээ нь бүх материаллаг зүйлсийн хувьд хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн байна.

ДҮГНЭЛТИЙН ҮНДЭСЛЭЛ

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн. Уг стандартын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагаа энэ тайлангийн Санхүүгийн тайлангийн талаарх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол Улсын Мэргэшсэн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрмийн санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой зохих шаардлагуудын дагуу тус байгууллагаас хараат бус бөгөөд эдгээр ёс зүйн шаардлагуудад нийцүүлэн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Олж авсан аудитын баримт нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж итгэж байна.

УДИРДЛАГА БОЛОН ЗАСАГЛАХ ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДҮҮДИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХҮЛЭЭХ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэгтэй бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Удирдлага нь санхүүгийн тайланг гаргахдаа байгууллагын үйл ажиллагааг зогсоох юм уу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангаа гаргахдаа тасралтгүй байх зарчмын дагуу зогсолтгүй үйл ажиллагаа явуулах байгууллагын чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ. Засаглах эрх бүхий этгээдүүд нь байгууллагын санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТАД ХҮЛЭЭХ АУДИТОРЫН ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үл үндэслэлтэй нотолгоо олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Үл үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөртүвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог. АОУС-ын дагуу аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл ашиглаж, аудитын ажлын явцад мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан ажилладаг. Үүнд:

ИНТЕР АЗИАТ ХКК

№ 01 орноо 2025.03.11

- 1 Залилан эсвэл алдааны улмаас тусдаа санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай ба зохистой аудитын баримт нотолгоог олж авдаг. Залилангаас үүссэн материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг, учир нь залиланд хуйвалдаан, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.
- 2 Байгууллагын дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бус тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоодхяналтын талаар ойлголт олж авдаг.
- 3 Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн байгууллагын тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоондоо үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, эсвэл нөхцөл байдал байгууллага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах боломжгүй болгоход хүргэж болно.
- 4 Тодруулгыг багтаагаад тусдаа санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлж тусдаа санхүүгийн тайланд үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар гол гол ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг тодорхойлдог.

Бид бусад асуудлуудын дундаас аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа болон аудитын явцад тодорхойлсон дотоод хяналтын аливаа мэдэгдэхүйц доголдлыг багтаагаад аудитын илэрсэн томоохон асуудлуудаар засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцдаг.

Бид мөн засаглах эрх бүхий этгээдүүдэд хараат бус байдлын талаарх холбогдох ёс зүйн шаардлагуудыг мөрдөж ажилласан болох мэдэгдлийг гаргаж өгсөн. Мөн бид хараат бус байдлаа хадгалахын тулд анхаарвал зохих харилцаа болон бусад асуудлын талаар засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдэгдсэн.


Засаглах эрх бүхий этгээдүүдтэй харилцсан мэдээллүүдээс санхүүгийн тайлангийн аудитын хамгийн ач холбогдолтой гэж үзсэн асуудлыг аудитын гол асуудлаар сонгож аудиторын тайлангийн "Гол асуудал" хэсэгт оруулсан. Бид аудиторын тайланд тусгасан эдгээр асуудлууд нь хууль тогтоомж, дүрэм журмаар хориглосон гэж үзээгүй тул оруулсан болно.

Хүндэтгэсэн,

"ИНТЕР АУДИТ" ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Тайлангийн огноо: 2025/03/11



**ХУРААНГУЙ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

2

АУДИТ ХИЙСЭН ХУРААНГУЙ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
	2023.12.31	2024.12.31
А. Үлдэгдлийн тэнцэл		
1. Мөнгөн хөрөнгө	30,147.96	22,948.20
2. Авлага	142,627.20	3,195,224,068.35
3. Урьдчилж төлсөн тооцоо	-	24,865,400.00
4. Бусад санхүүгийн хөрөнгө	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн	172,775.16	3,220,112,416.55
5. Үндсэн хөрөнгө	-	-
6. Биет бус хөрөнгө	-	-
7. Урт хугацаат хөрөнгө оруулалт	25,009,999,987.47	25,009,999,987.47
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	25,009,999,987.47	25,009,999,987.47
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	25,010,172,762.63	28,230,112,404.02
1. Богино хугацаат өглөг	25,010,841,594.88	26,131,815,225.24
2. Урт хугацаат өглөг	-	2,500,000,000.00
Өр төлбөрийн дүн	25,010,172,762.63	28,631,815,225.24
3. Өмч	11,187,900.00	11,187,900.00
4. Өмчийн бусад хэсэг	-	-
5. Нэмж төлөгдсөн капитал	-	-
6. Дахин үнэлгээний нэмэгдэл	-	-
7. Хуримтлагдсан ашиг, алдагдал	(11,856,732.25)	(412,890,721.22)
Эзэмшигчийн өмчийн дүн	(668,832.25)	(401,702,821.22)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧИЙН ДҮН	25,010,172,762.63	28,230,112,404.02
Б. ОРЛОГЫН ТАЙЛАН		
1. Борлуулалтын орлого	-	-
2. Борлуулсан бараа бүтээгдэхүүний өртөг	-	-
Нийт ашиг /алдагдал/	-	-
3. Бусад орлого	5,063,455.43	-
4. Борлуулалт, маркетингийн зардал	-	-
5. Ерөнхий ба удирдлагын зардал	6,636,798.03	14,350,000.00
6. Санхүүгийн зардал	736,600.00	386,683,988.97
7. Бусад зардал	-	-
8. Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-	-
Татварын өмнөх ашиг /алдагдал/	(2,309,942.60)	(401,033,988.97)
Орлогын албан татварын зардал	-	-
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	(2,309,942.60)	(401,033,988.97)
В. ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН		
1. Эхний үлдэгдэл	1,641,110.35	(668,832.25)
2. Нэмэгдсэн	-	-
3. Хорогдсон	2,309,942.6	401,033,988.97
4. Эцсийн үлдэгдэл	(668,832.25)	(401,702,821.22)
Г. МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН		
1. Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(13,789,559.84)	(18,699,528.76)
2. Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	-	-
3. Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	7,846,000.00	18,692,329.00
4. Валютын ханшийн зөрүү	-	-
5. Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(5,943,559.84)	(7,199.76)

АНТИ-ӨР АУДИТ ХХК

№ 01 огноо 2025.03.11

**2024 ОНЫ АУДИТ ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

3

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	/төгрөгөөр/	
		2023.12.31	2024.12.31
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ			
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	4	30,147.96	22,948.20
Дансны авлага	5	-	3,195,082,441.15
Хувьцааны авлага	-	-	-
Татвар, НДШ-ийн авлага	6	142,627.20	142,627.20
Бусад авлага	-	-	-
Бараа материал	-	-	-
Урьдчилж төлсөн зардал, тооцоо	7	-	24,865,400.00
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	-
Эргэлтийн хөрөнгийн дүн		172,775.16	3,220,112,416.55
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ			
Үндсэн хөрөнгө	-	-	-
Биет бус хөрөнгө	-	-	-
Урт хугацаат хөрөнгө оруулалт	8	25,009,999,987.47	25,009,999,987.47
Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө	-	-	-
Бусад эргэлтийн бус хөрөнгө	-	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		25,009,999,987.47	25,009,999,987.47
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		25,010,172,762.63	28,230,112,404.02
ӨР ТӨЛБӨР			
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Дансны өглөг	9	841,607.41	25,037,228,923.88
Хувьцааны өглөг	-	-	-
Цалингийн өглөг	-	-	-
Татварын өр	-	-	-
НДШ-ийн өглөг	-	-	-
Богино хугацаат зээл	10	-	1,000,000,000.00
Хүүний өглөг	11	-	94,586,301.36
Урьдчилж орсон орлого	-	-	-
Бусад богино хугацаат өр төлбөр	-	25,009,999,987.47	-
Богино хугацаат өр төлбөрийн дүн		25,010,841,594.88	26,131,815,225.24
УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР			
Урт хугацаат зээл	12	-	2,500,000,000.00
Хойшлогдсон татварын өр	-	-	-
Бусад урт хугацаат өр төлбөр	-	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн			2,500,000,000.00
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		25,010,841,594.88	28,631,815,225.24
ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ			
Өмч: - Хувийн	13	11,187,900.00	11,187,900.00
Нэмж төлөгдсөн капитал	-	-	-
Эздийн өмчийн бусад хэсэг	-	-	-
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	-	(11,856,732.25)	(412,890,721.22)
Эзэмшигчдийн өмчийн дүн		(668,832.25)	(401,702,821.22)
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН		25,010,172,762.63	28,230,112,404.02

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 өгийг 2025.03.11

АУДИТ ХИЙСЭН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	ТОД	/төгрөгөөр/	
		2023.12.31	2024.12.31
Борлуулалтын орлого /цэвэр/	-	-	-
Борлуулалтын өртөг	-	-	-
НИЙТ АШИГ /АЛДАГДАЛ/			
Түрээсийн орлого	-	-	-
Хүүгийн орлого	-	-	-
Ногдол ашгийн орлого	-	-	-
Эрхийн шимтгэлийн орлого	-	-	-
Бусад орлого	-	5,063,455.43	-
Борлуулалт, маркетингийн зардал	-	-	-
Ерөнхий ба удирдлагын зардал	14	6,636,798.03	14,350,000.00
Санхүүгийн зардал	15	736,600.00	386,683,988.97
Бусад зардал	-	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз /гарз/	-	-	-
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-	-
Биет бус хөрөнгө данснаас хассаны олз /гарз/	-	-	-
Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз /гарз/	-	-	-
Бусад ашиг /алдагдал/	-	-	-
Татварын өмнөх ашиг /алдагдал/		(2,309,942.60)	(401,033,988.97)
Орлогын татварын зардал	-	-	-
ТАТВАРЫН ДАРААХ АШИГ /АЛДАГДАЛ/		(2,309,942.60)	(401,033,988.97)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг /алдагдал/	-	-	-
Тайлант үеийн цэвэр ашиг /алдагдал/		(2,309,942.60)	(401,033,988.97)
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-
Бусад олз /гарз/	-	-	-
НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		(2,309,942.60)	(401,033,988.97)
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг /алдагдал/	-	-	-

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

НИТЭР АУДИТ ХХК
№ 01 өгнөө 2025.03.11

АУДИТ ХИЙСЭН ӨМЧИЙН ӨӨРЧӨЛӨЛТИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМЧ	НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ	ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ	ЭЗНИЙ ӨМЧИЙНБУСАД ХЭСЭГ	ХУРИМТЛАГДСАН АШИГ (АЛДАГДАЛ)	/Төгрөгөөр/ НИЙТ ДҮН
2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	11,187,900.00	-	-	-	(9,546,789.65)	1,641,110.35
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ	11,187,900.00	-	-	-	(9,546,789.65)	1,641,110.35
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(2,309,942.60)	(2,309,942.60)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл	11,187,900.00	-	-	-	(11,856,732.25)	(668,832.25)
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	-	-	-	-
ЗАЛРУУЛСАН ҮЛДЭГДЭЛ	11,187,900.00	-	-	-	(11,856,732.25)	(668,832.25)
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-	-	-	-	(401,033,988.97)	(401,033,988.97)
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-	-
Өмчид гарсан өөрчлөлт	-	-	-	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-	-	-	-
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	-	-	-	-	-
2024 ОНЫ 12 САРЫН 31-НИЙ ҮЛДЭГДЭЛ	11,187,900.00	-	-	-	(412,890,721.22)	(401,702,821.22)

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2025.03.11

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
<i>/төгрөгөөр/</i>		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	248,041.19	-
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	-	-
Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	-	-
Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	-	-
Буцаан авсан албан татвар	-	-
Татаас, санхүүжилтийн орлого	-	-
Бусад мөнгөн орлого	248,041.19	-
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	14,037,601.03	18,699,528.76
Ажилчдад төлсөн	3,448,128.26	-
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,266,506.63	-
Бараа материал худалдан авахад төлсөн	-	-
Ашиглалтын зардалд төлсөн	-	-
Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	-	-
Хүүний төлбөрт төлсөн	-	12,704,328.76
Татварын байгууллагад төлсөн	4,113,566.14	-
Даатгалын төлбөрт төлсөн	-	-
Бусад мөнгөн зарлага	5,209,400.00	5,995,200.00
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(13,789,559.84)	(18,699,528.76)
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	-	-
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	-	-
Биет бус хөрөнгө борлуулсны орлого	-	-
Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	-	-
Бусдад олгосон эзэл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	-	-
Хүлээн авсан хүүний орлого	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	-	-
Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	-	-
Бусдад олгосон эзэл болон урьдчилгаа	-	-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГО	7,846,000.00	1,244,692,329.00
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	7,846,000.00	1,244,692,329.00
Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	-	-
Бусад мөнгөн орлого	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГА	-	1,226,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	-	1,226,000,000.00
Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	-	-
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	7,846,000.00	18,692,329.00
Валютын ханшийн зөрүү	-	-
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	(5,943,559.84)	(7,199.76)
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	5,793,707.80	30,147.96
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	30,147.96	22,948.20

Хавсралт, тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 өгнөө 2025.03.11

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

4

"Өндөрхаан" ХК-ийн 2024 оны санхүүгийн
тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ БА ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА

"Өндөрхаан" ХК (цаашид Компани гэх) нь 2007 оны 10 дугаар сарын 25-ны өдөр Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан ба менежментийн зөвлөгөө өгөх үйл ажиллагааг явуулж байна.

Өндөрхаан ХК-ийн хувьцаа эзэмшигчид:

№	Хувьцаа эзэмшигчдийн нэр	Хувьцааны тоо	Нэгжийн үнэ	Дүн	Хувь
1	Ард Санхүүгийн Нэгдэл ХК	25,732	100	2,573,200	23.0%
2	Б.Батаа	15,132	100	1,513,200	13.5%
3	Ард Секюритиз ҮЦК ХХК	2,347	100	234,700	2.1%
4	Ард Кредит ББСБ ХК	2,238	100	223,800	2.0%
5	Бусад жижиг хувьцаа эзэмшигчид	66,438	100	6,643,000	59.3%

2. САНХҮҮГИЙН ТАЙЛАГНАЛЫН СУУРЬ ЗАРЧИМ

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДЭС:

Компанийн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-д нийцүүлэн бэлтгэсэн. Санхүүгийн тайлангууд нь санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, тайлбар тодруулгаас бүрдэж байна.

ҮНЭЛГЭЭ:

Санхүүгийн тайланд хөрөнгө, өр төлбөр, өмчийг түүхэн өртгийн зарчмаар хэмжиж бүртгэсэн.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭСЭН ВАЛЮТ:

Компанийн ажил гүйлгээний хэмжих нэгж нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөг (MNT) юм. Санхүүгийн тайлангийн тодруулгад тоон үзүүлэлтүүдийг төгрөгөөр бэлтгэсэн.

НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН СУУРЬ:

Санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн аккруэл суурьт зарчимд үндэслэн бэлтгэдэг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ТӨСӨӨЛӨЛ:

Мөрдөж байгаа хууль эрх зүйн болон бизнесийн орчинд компанийн цаашдын үйл ажиллагаанд нөлөөлөхүйц өөрчлөлт орох хандлага ба төсөөлөлгүй байна. Компани ирээдүйд үндсэн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэн явуулна гэсэн итгэл үнэмшилд тулгуурлан санхүүгийн тайлангаа бэлтгэсэн.

3. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ҮНДСЭН БОДЛОГУУД

МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, төлбөр гүйцэтгэх зориулалтаар банкин дахь харилцах дансанд байгаа мөнгөн хөрөнгүүдээс бүрдэнэ. Мөнгө ба түүнтэй адилтгах зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг. Гадаад валютаарх мөнгөн хөрөнгийг Монгол банкнаас зарласан тухайн өдрийн албан ханшаар төгрөгт хөрвүүлнэ.

МОНГОЛЫН ААР
№ 01 огноо 2025.03.11

ГАДААД ВАЛЮТЫН БҮРТГЭЛ

Санхүүгийн тайланг Монгол төгрөгөөр илэрхийлсэн бөгөөд компани үйл ажиллагаагаа явуулдаг албан ёсны мөнгөн тэмдэгт нь Монгол улсын мөнгөн тэмдэгт - Монгол төгрөг (MNT) юм. Гадаад улс орны валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөр, гүйлгээг тайлан гаргасан өдрийн Монгол банкаас зарласан албан ханшаар төгрөгт хөрвүүлж санхүүгийн тайланд тусгана.

Хөрвүүлэлтээс үүссэн гадаад валютын ханшийн зөрүүг орлого үр дүнгийн тайланд ашиг (алдагдал)-аар хүлээн зөвшөөрнө. Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн бус зүйлсийг нэрлэсэн үнээр нь бүртгэдэг бөгөөд нэрлэсэн үнийг тухайн өдрийн ханшаар хөрвүүлэн бүртгэлд тусгана.

САНХҮҮГИЙН ХӨРӨНГӨ**Анхдагч хүлээн зөвшөөрөлт**

Санхүүгийн хөрөнгийг анх удаа түүний бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхдагч шууд зардлыг бодит үнэ цэнийн хэмжилт дээр нэмж тооцдог. Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн анхдагч шууд зардал (гүйлгээний шимтгэл гэх мэт ажил гүйлгээний зардал)-ыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Ангилал

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө - Гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах зорилгоор эзэмшиж буй бизнесийн загвар бүхий санхүүгийн хөрөнгүүдийг энэ ангилалд хамруулна. Гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болно. Зээл болон авлагууд нь идэвхитэй зах зээл дээрх жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд хамаарна. Дансны авлага нь үндсэн үйл ажиллагааны явцад зээлээр борлуулсан бараа, бүтээгдэхүүн, үзүүлсэн ажил үйлчилгээний төлөө худалдан авагч болон харилцагчаас авах мөнгөн дүн байна. Дансны авлагыг анх СТОУС 9 Санхүүгийн Хэрэглүүр-ийн 5.1.3-д заасны дагуу СТОУС 15 Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого-д заасан мэдэгдэхүйц санхүүжилтийн хэлэлцээр агуулаагүй бол ажил гүйлгээ үнээр хэмжинэ.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгалыг хүлээн авах болон мөн арилжих зорилгоор эзэмшиж байгаа бол эдгээр хөрөнгийг бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь бусад дэлгэрэнгүй орлогоор тайлагнана. Мөн гэрээний нөхцөлийн дагуу тодорхойлсон өдрүүдэд үндсэн төлбөр болон үлдэгдэл төлбөрөөс бодогдсон хүүг хүлээн авах эрх бий болдог санхүүгийн хөрөнгө. Түүнчлэн тогтмол эсвэл тодорхойлж болохуйц төлбөр болон тогтсон хугацаа байхгүй дунд болон урт хугацаанд эзэмшихээр шийдсэн хөрөнгө оруулалтыг энэ ангилалд багтаана.

Ашиг, алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө - Бодит үнэ цэнд үндэслэн гүйцэтгэлийг нь үнэлж, удирдан зохицуулдаг санхүүгийн хөрөнгийг дээр дурдсан 2 аргын шаардлага хангаагүй тохиолдолд ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр илэрхийлэгдсэн санхүүгийн хөрөнгө гэж үзнэ. Өөрөөр хэлбэл тухайн санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн мэдээлэлд анхаарал хандуулдаг, тухайн хөрөнгийн гүйцэтгэлийг үнэлж, шийдвэр гаргахын тулд уг мэдээллийг ашигладаг, бизнесийн загварын хувьд гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах зорилгоор ч эзэмшдэггүй, мөн гэрээний мөнгөн гүйлгээг цуглуулах ба борлуулах зорилгоор ч эзэмшдэггүй бол энэ аргын дагуу тухайн хөрөнгө оруулалтыг бүртгэнэ. Ийм санхүүгийн хөрөнгийн хувьд гэрээний мөнгөн гүйлгээний цуглуулалт нь тухайн бизнесийн загварын зорилгыг биелүүлэхэд зөвхөн тохиолдлын шинжтэй үйл явдал байдаг. Өөрөөр хэлбэл, арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан авч, богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай санхүүгийн хөрөнгө хамаарна. Идэвхтэй зах зээлийн жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй, өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг энэ ангилалд хамааруулж ангилахгүй.

Дараа үеийн хэмжилт

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Тайлант үе бүрд үр ашигт хүүний аргыг ашиглан тооцсон хорогдуулсан өртгөөр хэмжинэ. Үр ашигт хүүний түвшнээр тооцсон хүүгийн орлогыг тайлант үеийн ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 орлого 2025.03.11

Бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Тайлант үе бүрийн эцэст бодит үнэ цэнээр нь санхүүгийн хөрөнгийг хэмжинэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзгыг дараах байдлаар толилуулна. Үүнд:

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө – Тайлант үеийн ашиг, алдагдлын бусад орлого эсвэл бусад зардлаар

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгө – үнэ цэнийн өөрчлөлтийг "бусад дэлгэрэнгүй орлого"-оор тус тус толилуулна.

Ашиг алдагдлаарх бодит үнэ цэнээр хэмжсэн хөрөнгөөс олсон хүүний орлогыг цэвэр олз, гарзаар тайлагнана

Бодит үнэ цэнийн тооцоолол

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдсан санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг (олон нийтэд арилжигдсан дериватив болон арилжааны үнэт цаас гэх мэт) тайлант өдрийн арилжаа дуусах үеийн зах зээлийн ханшид үндэслэнэ. Идэвхтэй зах зээл дээр нийтлэгдсэн үнийн саналууд байгаа нь бодит үнэ цэнийн хамгийн сайн нотолгоо бөгөөд хэрэв байгаа бол тэдгээрийг бодит үнэ цэнийг хэмжихэд ашигладаг. "Идэвхтэй зах зээл дээр үнэлэгдсэн" гэсэн хэллэг нь бирж, дилер, брокер, салбарын бүлэг, үнийн үйлчилгээ эсвэл зохицуулах агентлагаас санал болгож буй үнийг бэлэн бөгөөд тогтмол авах боломжтой гэсэн үг юм. Эдгээр үнэ нь зах зээлийн бодит ба тогтмол гүйлгээг илэрхийлдэг бөгөөд энэ нь хүндрэлтэй борлуулалт биш юм. Үнийг үндсэн зах зээлээс эсвэл үндсэн зах зээл байхгүй тохиолдолд хамгийн ашигтай зах зээлээс авч болно [СТОУС13(16)]. Зах зээлийн үнийг гүйлгээний зардалд тохируулах боломжгүй [СТОУС13(25)]. Санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо дараах түвшнийг хэрэглэнэ. Үүнд:

- I түвшин – Идэвхтэй зах зээл дээрх үнэ. Тухайлбал, арилжаа солилцооны зах зээл, дилер, брокер, оролцогчдын хоорондын зах зээл.
- II түвшин – Бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөөг шууд ба шууд бусаар үзүүлэх мэдээлэл. Тухайлбал: LIBOR ханшид суурилсан тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп, тодорхой банкны суурь ханшид суурилсан тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп.
- III түвшин – Бодит үнэ цэнд мэдэгдэхүйц нөлөөг үзүүлэх зах зээл дээр ажиглагддаг мэдээллийг ашиглах бусад аргачлалууд.

Санхүүгийн хөрөнгийн үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг данснаас хасна. Үүнд:

- Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан, эсвэл
- Уг эрхээ бусдад шилжүүлсэн бөгөөд тухайн хөрөнгийн эрсдэл өгөөж бүрэн шилжсэн эсвэл бүх эрсдэл өгөөжийг шилжүүлээгүй боловч захиран зарцуулах эрхийг нь шилжүүлсэн бол.

Бусад дэлгэрэнгүй орлогоорх бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгийг худалдан борлуулсан бол бусад дэлгэрэнгүй орлогоор өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн хэрэгжээгүй бодит үнэ цэнийн хуримтлагдсан дүнг тайлант үеийн ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдал нь санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөхүйц, дүнг тооцоолох боломжтой байгаа үед зөвхөн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 орлого 2025.03.11

Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Тайлант үе бүрд хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд хөрөнгийн дансны үнэ болон санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцно. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараагийн хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдал (зээлийн чанар сайжирсан г.м)-тэй холбоотойгоор үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын буцаалтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр хэмжсэн санхүүгийн хөрөнгө – Бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсны илтгэх бодитой нотолгоо байгаа бол худалдан авсан өртөг болон одоогийн бодит үнэ цэнэ (өмнө нь хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хассаны дараах) хоорондын зөрүүнээс хуримтлагдсан алдагдлаар өмчийг бууруулж, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байсан өмчийн хэрэглүүрт тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараагийн хугацааны туршид ашиг алдагдал руу буцаахгүй. Бодит үнэ цэнийн хэмжилтийг өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэн өсөлт эсвэл бууралт дараагийн үеүдэд өссөн эсвэл буурсан бол уг өсөлт, бууралтыг өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралтын нэгэн адил бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэнэ.

САНХҮҮГИЙН БУС ХӨРӨНГӨ, УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ, ТООЦОО

Гадаад болон дотоодын зах зээлээс түүхий эдматериал худалдан авахаар төлсөн төлбөр, бусад бэлтгэн нийлүүлэгч, гэрээ гүйцэтгэгчид төлсөн урьдчилгааг нэрлэсэн үнээр нь хэмжиж, урьдчилж төлсөн зардал, урьдчилж төлсөн тооцооны хэсэгтнэрийн данс нээж бүртгэдэг.

ДАНСНЫ БА БУСАД АВЛАГА

Авлагыг худалдан авагч, харилцагчдаас нэхэмжилсэн дүнгээр хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Компанийн нягтлан бодох бүртгэлийн зохион байгуулалт нийцүүлэн авлагыг төрөл зүйлээр ангилан санхүүгийн тайланд тусгана.

БАРАА МАТЕРИАЛ

Бараа материалыг олж бэлтгэсэн өртгөөр үнэлэн, ижил төрлийн хөрөнгүүдийг эхэлж авснаа эхэлж зарлагадах аргаар бүртгэнэ. Аж ахуйн ба хангамжийн материал, бараа, бүтээгдэхүүнийг төрөл зүйлээр ангилан санхүүгийн тайланд бүлэглэн үзүүлнэ.

ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Үндсэн хөрөнгийг нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, хүлээн зөвшөөрөх нөхцөлийн дагуу, анхны өртгөөр хэмжиж үнэлэн зохих ангиллын дансанд бүртгэнэ. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авалтын өртөг, хөрөнгийг ашиглалтын хэвийн нөхцөлд оруулахад шууд хамаарах зардлаас бүрдэнэ. Анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл, үнэ цэний бууралтын алдагдлыг хассан цэвэр дүнгээр санхүүгийн тайланд тусгана.

САНХҮҮГИЙН ӨР ТӨЛБӨР

Ангилал

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг.

- *Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*
- *Хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн өр төлбөр*

Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2025.03.11

Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр - Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

Бусад санхүүгийн өр төлбөр - Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүний түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүний зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү, эсвэл купон багтана. Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүний түвшинг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

Компани санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

ӨӨРИЙН ХӨРӨНГӨ

Тайлангийн өмнөх үеийн ба тайлант оны хуримтлагдсан ашгийг тооцоологдсон дүнгээр хүлээн зөвшөөрч өөрийн хөрөнгийн бүлэгт тусган үзүүлнэ.

БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО

Компани нь орлого хүлээн зөвшөөрөхдөө СТОУС 15 Худалдан Авагчидтай Байгуулсан Гэрээний Орлого-ыг мөрддөг. Уг стандартад заасны дагуу Компани нь гэрээгээр нийлүүлэхээр амласан бүтээгдэхүүн, үйлчилгээний хяналт шилжсэн үед орлогыг хүлээн зөвшөөрнө. Хяналтыг СТОУС-ын Үзэл баримтлалын 4.20-д "аливаа хөрөнгөөс үүсэх эдийн засгийн үр өгөөжийг захиран зарцуулах, удирдах чадамж" гэж тодорхойлсон байдаг.

Гэрээгээр нийлүүлэхээр амласан бүтээгдэхүүн, үйлчилгээний шинж чанар, гэрээний бусад нөхцөлүүдээс хамааран орлогыг тодорхой хугацааны туршид хэсэгчлэн хүлээн зөвшөөрөх, эсвэл тодорхой нэг хугацаанд хүлээн зөвшөөрөх гэж ангилна.

Орлогыг аливаа хөнгөлөлт, үнэ цэний бууралт, борлуулалттай холбоотой бусад төлбөрийг хассаны дараа хүлээн авсан эсвэл хүлээн авахаар хүлээгдэж буй төлбөрийн бодит үнэ цэнээр хэмжиж үнэлнэ.

БОРЛУУЛСАН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ӨРТӨГ

Компани нь гэрээний үүргийн биелэлтийн гүйцэтгэлтэй уялдуулан өртгийг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Гэрээний үүрэг дуусаагүй, гүйцэтгэх явцад гэрээт ажилтай холбоотой гарсан шууд зардлыг дуусаагүй үйлдвэрлэл дансанд хуримлуулан бүртгэдэг.

ЗАРДАЛ

Компанийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий ба удирдлага, борлуулалт болон маркетингийн зардлуудыг аккруэл сууриар хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Зардлуудыг нягтлан бодох бүртгэлийн ба санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, холбогдох заавар журмын аргачлалд нийцүүлэн төрлөөр ангилж орлогын тайланд үзүүлнэ.

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2025.03.11

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
4. МӨНГӨ, ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ		
Касс дахь бэлэн мөнгө	2,354.81	2,354.81
Банкин дахь мөнгө	27,793.15	20,593.39
ДҮН	30,147.96	22,948.20

Тайлбар: Компани нь Хас Банкнд харилцах данс эзэмшдэг бөгөөд тайлангийн өдрөөрх дансны үлдэгдлийг дээр харуулав.

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
5. ДАНСНЫ АВЛАГА		
Дансны авлага	-	3,195,081,441.15
ДҮН	-	3,195,081,441.15

Тайлбар: Компани нь Ард Санхүүгийн Нэгдэл ХК-с дээрх дүнгээр авлагатай байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
6. ТАТВАР, НДШ-ИЙН АВЛАГА		
Татвар, НДШ-ийн авлага	142,627.20	142,627.20
ДҮН	142,627.20	142,627.20

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
7. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ТООЦОО		
Урьдчилж төлсөн тооцоо	-	24,865,400.00
ДҮН	-	24,865,400.00

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
8. УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
Урт хугацаат хөрөнгө оруулалт		
Ардын Тэтгэврийн Данс ХХК	10,010,000,000.00	10,010,000,000.00
MNP /Монгол Шуудан ХК/	8,383,831,791.00	8,383,831,791.00
TNGR /Тэнгэрлэг Медиа Групп ХК/	6,616,168,196.00	6,616,168,196.00
ДҮН	25,009,999,987.47	25,009,999,987.47

Тайлбар: Компани нь Ардын Тэтгэврийн Данс ХХК, Монгол Шуудан ХК болон Тэнгэрлэг Медиа Групп ХК-д хувьцаагаар хөрөнгө оруулсан бөгөөд тайлант онд ногдол ашгийн орлого олоогүй байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
9. ДАНСНЫ ӨГЛӨГ		
Бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг	841,607.41	27,228,936.41
Хувьцааны өглөг		
Ард Санхүүгийн Нэгдэл ХК	-	20,609,999,987.47
Бусад охин компани	-	4,400,000,000.00
ДҮН	841,607.41	25,037,228,923.88

Тайлбар: Компанийн дансны өглөг нь бэлтгэн нийлүүлэгчдэд өгөх өглөг болон Ард Санхүүгийн Нэгдэл ХК, бусад охин компаниудад төлөх өглөгөөс бүрдэж байна.

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2025.03.11

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
10. БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ		
Богино хугацаат зээл	-	1,000,000,000.00
ДҮН	-	1,000,000,000.00

Тайлбар: Компани нь тайлант онд Ард Кредит ББСБ ХК-с авсан 12 сарын хугацаатай 1,000,000.0 мянган төгрөгийн зээлийг уг дансанд бүртгэсэн.

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
11. ХҮҮГИЙН ӨГЛӨГ		
Хүүгийн өглөг	-	94,586,301.36
ДҮН	-	94,586,301.36

Тайлбар: Компани нь урт болон богино хугацаат зээлийн хүүгийн өглөгийг уг дансанд хуримтлуулан бүртгэсэн.

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
12. УРТ ХУГАЦААТ ЗЭЭЛ		
Урт хугацаат зээл	-	2,500,000,000.00
ДҮН	-	2,500,000,000.00

Тайлбар: Компани нь тайлант онд Ард Актив ХЗХ-с 24 сарын хугацаатай 2,500,000.0 мянган төгрөгийн зээл авсан ба урт хугацаат зээл дансанд бүртгэсэн.

ҮЗҮҮЛЭЛТ	ЭРГЭЛТЭД БАЙГАА БҮРЭН ТӨЛӨГДСӨН ЭНГИЙН ХУВЬЦАА		ДАВУУ ЭРХТЭЙ ХУВЬЦАА		ӨМЧИЙН ДҮН (ТӨГРӨГӨӨР)
	ТОО ШИРХЭГ	ДҮН (ТӨГРӨГӨӨР)	ТОО ШИРХЭГ	ДҮН (ТӨГРӨГӨӨР)	
13. ӨМЧ					
Эхний үлдэгдэл	111,879	11,187,900.00	-	-	11,187,900.00
Нэмэгдсэн	-	-	-	-	-
Хасагдсан	-	-	-	-	-
ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	111,879	11,187,900.00	-	-	11,187,900.00

Тайлбар: Компанийн дүрмийн сан нь нэг бүр нь 100.00 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 111879 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэж байна.

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
14. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ		
Ажилчдын цалингийн зардал	4,491,083.88	-
Аж ахуйн нэгжээс төлсөн НДШ-ийн зардал	752,414.15	-
Бичиг хэргийн зардал	66,000.00	-
Шуудан холбооны зардал	129,900.00	-
Мэргэжлийн үйлчилгээний зардал	1,100,000.00	14,350,000.00
Хүлээн авалтын зардал	31,400.00	-
Бусад зардал	66,000.00	-
ДҮН	6,636,798.03	14,350,000.00

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 өгнөө 2025.03.11

ҮЗҮҮЛЭЛТ	2023.12.31	2024.12.31
15. САНХҮҮГИЙН ЗАРДАЛ		
Хүүгийн зардал	736,600.00	386,669,588.97
ДҮН	736,600.00	386,669,588.97

Тайлбар: Компани нь тайлант хугацааны зээлийн хүүгийн зардлыг уг дансанд бүртгэж тайлагнасан.

16. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА БА БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛС

Бусад хууль тогтоомж, зохицуулагч байгууллагуудаас гаргасан дүрэм, журамтай холбоотой ямар нэгэн үүрэг хариуцлага үүсгэж болохуйц үйл явдал үүсээгүй байна.

17. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Энэхүү тайланг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдөр бэлтгэсэн. Тасалбар болгосноос хойш тайланд нөлөөлөх үйл явдал гараагүй.

18. ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Компанид Тодруулгын "Үүрэг хариуцлага ба болзошгүй зүйлс" хэсэгт тусгагдсан эрсдэлүүдээс гадна санхүүгийн хэрэгслүүдийг хэрэглэх явцад дараах эрсдэлүүд тулгарч болно.

- Зээлийн эрсдэл
- Төлбөрийн чадварын эрсдэл
- Зах зээлийн (гадаад валют)
- Зах зээлийн эрсдэл (хүүний түвшин болон үнэ цэнийн эрдэл)

Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэж харилцагч гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас хүлээх эрсдэл юм. 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар бусдаас шаардах эрхтэй санхүүгийн хөрөнгө 3,195,081.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна. Уг дүн нь бүхэлдээ холбоотой талаас авах авлага байна.

Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг нь өрийн хэрэглүүрийн эргэн төлөлтөөс үүсдэг эрсдэл юм. Эргэн төлөлт ба санхүүжилтийн хэрэгцээ хангагдаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд компани өөрийн үйл ажиллагааны мөнгөн урсгал, санхүүжилтийг идэвхтэй удирддаг.

Зах зээлийн эрсдэл (Гадаад валютын эрсдэл)

Гадаад валютын эрсдэл гэдэг нь төгрөгөөс бусад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээний ханшийн өөрчлөлтөөс үүсэх санхүүгийн хүндрэл юм. Гадаад валютын ханшийн эрсдэлээс сэргийлэхийн тулд зах зээл дээрх хамгийн боломжит ханшийг баримтлах бодлого баримталдаг.

Зах зээлийн эрсдэл (Хүүний түвшний эрсдэл)

Хүүний түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дээрх хүүний түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйд гарах мөнгөн гүйлгээний хэлбэлзэх эрсдэл юм.

Зах зээлийн эрсдэл (Бодит үнэ цэнийн эрсдэл)

Бодит үнэ цэнийн эрсдэл гэдэг нь зах зээл дээр ханшийн өөрчлөлтийн улмаас эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнэ буурах эрсдэл юм. Бодит үнэ цэнийн эрсдэлээс сэргийлэхийн тулд зах зээл дээрх хамгийн боломжит ханшийг баримтлах бодлого баримталдаг.

ИНТЕР АУДИТ ХХК

№ 01 огноо 2025.03.11

"ИНТЕР АУДИТ" ХК

Аудитын компанийн хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, 5-р хороо, 6-р
хороолол, Самбуугийн гудамж, Эм
Эн тауэр, 802 тоот

Холбогдох:

Утас: 99004839
Веб хуудас: www.interaudit.mn
Фэйсбүүк хуудас: Интер Аудит ХК / Inter Audit LLC
Мэйл хаяг: info@interaudit.mn

ИНТЕР АУДИТ ХХК
№ 01 огноо 2025.03.11